

Монголын Гүйцэтгэх Захирлуудын Судалгаа 2013 он



Өмнөх үг



Монголын Гүйцэтгэх Захирлуудын дунд 2 дахь жилдээ хийсэн судалгааны үр дүнг та бүхэндээ толилуулж байгаадаа бид баяртай байна.

Энэ жилийн судалгаанаас үзэхэд “Өсөлтийг бий болгогч болон саад бологч хүчин зүйлүүд” сэдэв судалгаанд хамрагдагсдын анхаарлыг хамгийн ихээр татсан нь онцлог байлаа. Монголын Гүйцэтгэх Захирлууд байгууллагаа харилцагчдад нийцүүлэн өөрчлөн шинэчилж байгаа үзэгдлээс дэлхийн чиг хандлагыг дагаж буй дүр зураг харагдлаа. Харилцагчид ба үйлчлүүлэгчид компанийн бизнес бодлогыг тодорхойлогч хүчин зүйл болсноос үүдэн ирэх жилийн нэн тэргүүний зорилт нь харилцагчдын тоог өсгөх явдал хэмээн үзэж байна. Мөн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг сайжруулах хийгээд чадварлаг ажиллах хүчнийг бий болгох нь тус судалгааны удаах онцлох сэдвүүдээр тодорлоо.

Сүүлийн үед Гүйцэтгэх Захирлуудын дийлэнх нь өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан дотоодын зах зээл дээрх байр сууриа өсгөх болон шинэ бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох боломжуудыг илүү анхаарч ажиллахаа илэрхийлснийг тус судалгаанаас олж мэдэж болно.

Мөн Гүйцэтгэх Захирлууд ирэх жилийн өсөлтөнд итгэж найдахгүй байгаа ч урт хугацаанд өснө гэж үзэж байна. Монголын Гүйцэтгэх Захирлуудын гуравны нэг нь ирэх 12 сард компанийн орлого өснө гэдэгт “маш итгэлтэй” байна гэсэн хэдий ч энэ нь өнгөрсөн оны үзүүлэлтээс хоёр дахин буурчээ.

2013 оны хувьд дотоодын эдийн засаг сайжирна гэж үзсэн Монголын Гүйцэтгэх Захирлуудын хувь илт буурсан байна (2012 онд 90 хувь ба 2013 онд 44 хувь). Үүнээс гадна өнгөрсөн жилийн хувьд дотоодын эдийн засгийн үзүүлэлт

буурна гэж нэг ч захирал үзээгүй бол харин 2013 онд эдийн засгийн үзүүлэлт буурна гэж судалгаанд хамрагдагсдын 19 хувь нь хариулжээ.

Хаврын тэнгэр мэт байнгын өөрчлөмтгий уур амьсгалд дасан зохицож үйл ажиллагаа явуулах нь Монголын бизнесмэнүүдийн хувьд шинэ зүйл биш болжээ.

Мэдээжийн хэрэг, компанийн Гүйцэтгэх Захирлууд тоглоомын дүрмийн өөрчлөлтийг хөндлөнгөөс ажиж суухаас илүүтэйгээр энэхүү өөрчлөлтөнд тохируулан үйл ажиллагаагаа уялдуулахад бэлэн байгаа нь ажиглагдсан.

Эцэст нь, энэхүү судалгаанд хамрагдсан бүх Гүйцэтгэх Захирлууддаа, ялангуяа бизнесийн өнөөгийн орчинд тулгамдаж буй асуудлууд болон шинэ боломжуудын талаарх өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй хуваалцаж, цаг зав гаргаж ярилцлага өгсөн Гүйцэтгэх Захирлууддаа компанийхаа хамт олны нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Мөн та бүхэн манай дэлхийн бусад улс орнууд дахь салбар компаниудын Гүйцэтгэх Захирлуудын Судалгааны нэгтгэсэн тайлангийн бүрэн эхийг www.pwc.com/ceosurvey -ээс авч үзнэ үү.

Хүндэтгэсэн,
Мэттью Поттл
Монгол дахь Удирдах Партнер
PwC

2013 онд Монголын Гүйцэтгэх Захирлуудын анхаарлыг татаж буй асуудлууд

Ирэх жилд Монголын Гүйцэтгэх Захирлууд бизнесээ удирдахдаа өөрсдийгөө болон удирдлагын багаа дараах асуудлуудад хандуулахаар төлөвлөж байна. Бидний явуулсан энэхүү судалгаанд Монголд бизнес эрхлэгч 31 Бизнес удирдагч нар оролцсон бөгөөд дараах сэдвүүдийн талаарх ойлголтыг та тэдний хариултаас авах болно. Үүнд:

Өсөлтөнд итгэх итгэл	Өөрчлөлтийн хөдөлгүүрүүд: Үнэ цэнээ хамгаалах уу, үнэ цэнээ бий болгох уу?
Олон улсын зах зээлийг харах өнцөг	Бүтцийн шинэчлэл
Өсөлтийн эх үүсвэр	Компанийн нийгмийн хариуцлага
Нэн тэргүүний асуудлууд	Чадварлаг ажилчидтай холбоотой асуудлууд
Өсөлтөнд саад бологч бизнесийн хүндрэлүүд	Хөдөлмөрийн зах зээлийн ерөнхий төлөв
Өсөлтөнд саад бологч эдийн засгийн асуудлууд	Ур чадварын дутагдлыг нөхөх арга хэмжээ
Стратеги хөгжил	

Өсөлт: Итгэл

Монголын захирлууд 2013 оны байдлаар ойрын хугацаанд өснө гэдэгт дэлхийн захирлуудыг бодвол итгэл муутай байна.

Та компанийнхаа орлогыг ирэх 12 сард өснө гэдэгт хэр итгэлтэй байна вэ?

■ Маш итгэлтэй



... Ирэх 3 жилийг илүү өөдрөгөөр харж байна

Та компанийнхаа орлогыг ирэх 3 жилд өснө гэдэгт хэр итгэлтэй байна вэ?

■ Маш итгэлтэй



Зах зээл: Эерэг хүлээлт

2012 онтой харьцуулахад 2013 онд Монголын захирлууд дэлхийн эдийн засгийг илүү нааштайгаар харж байна.

Таны бодлоор ирэх 12 сард дэлхийн эдийн засаг сайжрах уу, хэвэндээ байх уу, буурах уу?



... Дотоодын эдийн засгийг итгэл муутайгаар харж байна

Таны бодлоор ирэх 12 сард дотоодын эдийн засаг сайжрах уу, хэвэндээ байх уу, буурах уу?



Өсөлт: Эх үүсвэр

Ойрын хугацаанд өснө гэдэгт итгэл муутай байна. Мөн дотоодын зах зээлд органик бусаар өсөх итгэл буурах хандлага илэрч байна.

Таны хувьд ирэх 12 сард дараах зүйлсийн аль нь бизнесийг өсгөх үндсэн боломж гэж үзэж байна вэ?



Дотоод санхүүжилтийн эх үүсвэрт илүү их найдах боллоо

Та ирээдүйн өсөлтийг хэрхэн санхүүжүүлэхээр төлөвлөж байна вэ?




**Үйл ажиллагаагаа сайжруулах
болон шинэ үйлчлүүлэгчийг
татах**


**Юунд хөрөнгө оруулах тал
дээр Монголын захирлууд
дэлхийн захирлуудтай
санал нэг байна.**

**Ирэх 12 сард ямар
үндсэн гурван талбарт
хөрөнгө оруулалт хийхээр
зэхэж байна?**

Монгол 2013



Дэлхийн бусад улс орнууд 2013



Өсөлтөнд саад бологч бизнесийн хүчин зүйлүүд: Татвар биш

2013 оны дэлхийн захирлуудын тодорхойлсон бизнесийн бэрхшээлүүд:

- Татвар нэмэгдүүлэх (63%)
- Гол ур чадвартай ажилчдын хүрэлцээтэй байдал (58%)
- Эрчим хүчний үнэ ба хүрэлцээтэй байдал (52%)


Монголын захирлууд дэлхийн захирлуудтай харьцуулахад татвар нэмэгдүүлэхийг бизнесийн ноцтой асуудал гэж үзэх нь харьцангуй бага байна.

Монголын захирлууд өнгөрөгч онтой харьцуулахад бизнесийн бэрхшээлүүдийг эерэгээр харах болсон нь дараахад харагдах хоёр оны харьцуулсан үзүүлэлтээс харагдана:

- Хөдөлмөрийн зах зээл
- Ханган нийлүүлэгчийн сүлжээ
- Үндсэн дэд бүтэц
- Эрчим хүч

Бизнесийн өсөлтөнд тань саад болох магадлалтай бизнесийн шинжтэй асуудлуудад та хэр санаа зовниж байна вэ?

Нийлбэр дүн (санаа зовниж буй болон ихэд санаа зовниж буй)



**Өсөлтөнд саад бологч эдийн засгийн хүчин зүйлүүд:
Төрийн хэт их оролцоо**

Хөрөнгийн зах зээлийн тогтворгүйжил болон санхүүгийн алдагдалд засгийн газрын хийх зохицуулалтын талаар Монголын захирлууд дэлхийн захирлуудаас харьцангуй бага санаа зовнилттой байна.

Нөгөө талаар, Монголын захирлууд дараах бэрхшээлүүдэд илүү их санаа зовниж байна.

Үүнд:

- **Төрийн хэт их оролцоо**
- **Үндэсний засгийн газрын хардах хандлага**
- **Авилгал, хээл хахууль**

Бизнесийн өсөлтөнд тань саад болох магадлалтай эдийн засгийн шинжтэй асуудлуудад та хэр санаа зовниж байна вэ?

Нийлбэр дүн (санаа зовниж буй болон ихэд санаа зовниж буй)

■ Монгол 2013 ■ Дэлхийн бусад улс орнууд 2013




Стратеги хөгжил

Монгол дахь захирлууд компанийнхаа стратегийг өөрчлөх хандлага дэлхийн захирлуудынхаас илүү хүчтэй байна.

Ирэх 12 сард танай компаний стратеги хэр их өөрчлөгдөх вэ?


■ Дэлхийн бусад улс орнууд 2013 ■ Монгол 2012 ■ Монгол 2013



Компанийн стратегийг хэрэгжүүлэхэд чадварлаг ажилчдаар дутах явдал асуудал болохгүй гэж үзсэн. Монголын гүйцэтгэх захирлууд ирэх жилүүдийн стратегийг хэрэгжүүлэхэд явцдаа шаардагдах чадварлаг ажиллах хүчнийг бий болгоно, хөгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Ирэх 3 жилд компанийнхаа стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах чадварлаг ажилчдаар хангагдана гэдэгт хэр итгэлтэй байна вэ?

■ Монгол 2013




**Өөрчлөлтийн хөдөлгүүрүүд:
Үнэ цэнээ хамгаалах уу эсвэл
бий болгох уу?**

Өнгөрөгч онд Монголын захирлууд голчлон урт хугацаат хөрөнгө оруулалтын төслүүдийг (судалгаа хөгжүүлэлт, технологи, ур чадварын удирдлага г.м) анхаарч үзэж байсан бол энэ жилээс үнэ цэнийг хамгаалахад чиглэсэн өөрчлөлтүүд хийх (байгууллагын нэр хүнд, захирлуудын зөвлөлийн идэвхтэй оролцоо, эрсдлийн удирдлага ба компанийн засаглал) асуудлуудад илүү их анхаарлаа хандуулах болсон байна.

Ирэх 12 сард захирлууд компанийнхаа дараах талбаруудад томоохон өөрчлөлт хийхээр төлөвлөж буй байдал

■ Монгол 2013 ■ Монгол 2012




Дотоод төвлөрөл

Монголын захирлууд бизнесийн шинэчлэлт зохион байгуулалтад хандах хандлага нь дэлхийн захирлуудынхаас дараах 2 зүйл дээр илт ялгарсан ба харин бусад зүйлсийн хувьд үл ялиг л ялгаатай байна. Үүнд:

- Дэлхийн захирлууд зардлаа бууруулахыг илүүтэйгээр анхаарч байна
- Монголын захирлууд хил давсан компанийн нэгдэл ба худалдан авалтаас илүүтэйгээр стратегийн түншлэл ба хамтарсан хөрөнгө оруулалтыг дэмжиж байна

Гүйцэтгэх захирлуудын одоо хэрэгжүүлж байгаа болон ирэх 12 сард хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бүтцийн өөрчлөн шинэчлэлийн үйл ажиллагаанууд

■ Монгол 2013 ■ Дэлхийн бусад улс орнууд 2013



Зөв зүйл хийх


Нийгмийн хариуцлага болон тогтвортой байдлын бодлогоо өнгөрсөн жил боловсруулсан явдал байв.

Тухайн бодлогыг хэрэгжүүлэх олон шалтгаан байж болох хэдий ч хэрэгжүүлэх болсон шалтгаанаа “Үүнийг хийх нь зөв зүйтэй” байсан гэж олонхи нь тайлбарласан.

Танай байгууллага нийгмийн хариуцлага болон тогтвортой байдлын бодлого хэрэгжүүлэх үү?



Энэ бодлогыг хэрэгжүүлснээр юунд хүрэхээр зорьж байна вэ?



2013 оны хувьд байгууллагын хандив болон хөрөнгийн сан босгох үйл ажиллагаа хумигдсан

Нийгмийн хариуцлагын болон тогтвортой байдлын стратегийн элементүүд:
2013 оны зонхилох 4 элемент

Нийгмийн хариуцлагын болон тогтвортой байдлын стратегийн элементүүд:
2012 оны зонхилох 4 элемент

2013	2012
<i>1. Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал</i>	<i>1. Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал</i>
<i>2. Сургалт болон мэдлэг дээшлүүлэх бусад хөтөлбөрүүд</i>	<i>2. Сургалт болон мэдлэг дээшлүүлэх бусад хөтөлбөрүүд</i>
<i>3. Үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг удирдах</i>	<i>3. Үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг удирдах</i>
<i>4. Ус, эрчим хүчний үр ашиггүй хэрэглээг бууруулах</i>	<i>4. Байгууллагын хандив болон хөрөнгийн сан босгох үйл ажиллагаа</i>

**Чадварлаг ажилтантай холбоотой асуудлууд:
Зардал өсөхийн хажуугаар чанарын асуудал хөндөгдөж байна**

Захирлууд сүүлийн 12 сарын байдлаар ур чадварлаг ажилчдын дутагдал компанийн өсөлт болон ашиг орлогод дараах байдлуудаар нөлөөлсөн гэж үзсэн байна



Хөдөлмөрийн зах зээлийг өөдрөгөөр харах боллоо

Зөв тохирсон ажилтныг олж авахад илүү хялбар болсныг олон захирлууд хүлээн зөвшөөрч байна

Өмнөх жилтэй харьцуулахад таны үйл ажиллагаа эрхэлдэг бизнесийн салбарт ажилтан авахад илүү хүндрэлтэй, хялбар эсвэл хэвээрээ байгаа эсэх?



.....Нөгөө талаар, өндөр чадвар бүхий дунд түвшний менежерүүд хангалтгүй байгаа бөгөөд тэд хамгийн эрсдэлтэй ангилалд багтаж байна

Таны хувьд аль ангиллын ажилчдыг ажилд авах болон тогтвор суурьшилтай ажиллуулахад хүндрэлтэй байгаа вэ?



Олон улсын хөдөлмөрийн нөөц

Захирлууд гадаадад эрхэлдэг үйл ажиллагаандаа илэрч буй ур чадварын дутагдлыг нөхөхдөө технологийн иж бүрдэл нэвтрүүлэх эсвэл тодорхой ур чадвар бүхий компаниудыг худалдан авахаас илүүтэйгээр түншийн холбоо байгуулах (болон/ эсвэл аутсорсинг хийх буюу зарим ажлаа өөр компаниар хийлгэх) хэлбэрийг сонгож байна.

Ур чадварын дутагдалаас болж үйл ажиллагаагаа зогсоохгүй нь илт байна.

Ирээдүйн гадаадад эрхэлдэг үйл ажиллагааныхаа ажиллах хүчний талаар дараах өгөгдлүүдтэй санал нийлсэн болон баттайгаар санал нийлсэн захирлуудын хувь



2013 оны Монголын Гүйцэтгэх Захирлуудын Судалгааны талаар

2012 болон 2013 онуудад 2-5 сард явуулсан анхны болоод удаах судалгаануудад маань тус бүр Монголын дотоодын болон олон улсын 31 компани оролцсон болно.

2013 оны судалгааны хүрээнд бид Монголд суурин бизнес эрхлэгч гурван Гүйцэтгэх Захиралтай дэлгэрэнгүй ярилцлага хийсэн нь судалгаанд маань нилээд ач холбогдлыг нэмэрлэсэн билээ.

PwC-н 16 дахь жилдээ эрхлэн гаргасан 2013 оны Глобал Гүйцэтгэх Захирлуудын Судалгаа нь дэлхийн 68 оронд 2012 оны 9 сарын 5-аас 12 сарын 4-ний хооронд 1330 ярилцлагад тулгуурлаж хийгдсэн болно.

Глобал Гүйцэтгэх Захирлуудын Судалгааг татах: <http://www.pwc.com/ceosurvey>.
Эл судалгааг татах: <http://www.pwc.com/mn>.

Тайлбар: ‘Аль нь ч биш’, ‘Мэдэхгүй’ хариултуудыг оруулаагүй тул бүх үзүүлэлтийн нийлбэр 100%-д хүрэхгүй байх тохиолдол бий.

*Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
дараах хүмүүстэй холбоо барина уу:*

Монгол

Мэттью Поттл

Удирдах Партнер
+(976) 70009089 д.д.2003
matthew.f.pottle@mn.pwc.com

Олга Хардаева

Менежер
+(976) 70009089 д.д.2054
olga.khardaeva@mn.pwc.com

Баярсайханы Солонго

Бизнесийн Хөгжлийн Ажилтан
+(976) 70009089 д.д.2021
solongo.bayarsaikhan@mn.pwc.com

Глобал

Сузанн Снөвдн

Олон Улсын Судалгаа
+44 (0)20 7212 5481

www.pwc.com/mn

PwC нь байгууллага болон хувь хүнд үнэ цэнийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Бид дэлхийн 158 оронд 184 000 гаруй ажилтантайгаар аудит, татвар, зөвлөх үйлчилгээг чанарын өндөр түвшинд хүргэхээр зорьж ажиллаж байна. Манай компаний талаар илүү их мэдэхийг хүсвэл www.pwc.com хаягаар зочилно уу.
© 2013 ПрайсуотерхаусКуперс. Бүх эрх нь хамгаалагдсан. PwC нь PwC-ийн сүлжээг эсвэл PwC-ийн сүлжээний бие даасан хуулийн этгээдүүд болох нэг эсвэл хэд хэдэн гишүүн байгууллагыг илэрхийлнэ. Манай байгууллагын бүтцийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй www.pwc.com/structure цахим хуудаснаас танилцана уу.
Энэхүү судалгааны агуулга нь зөвхөн ерөнхий тойм ойлголт өгөх зорилготой бөгөөд мэргэжлийн зөвлөхүүдийг орлуулах хэрэгсэл болгон ашиглагдахад зориулагдаагүй болно.